293

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон Жанжин Д.Сүхбаатарын талбай
5 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.09.20 № ХЭГ/1759

танай _____-ны №_____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХТУЯА ТАНАА

Асуултын хариу хүргүүлэх тухай

Боловсролын салбарын хамтын хэлэлцээрийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуултын хариуг холбогдох Засгийн газрын гишүүдээс бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцахыг хүсье.

Хавсралт 2 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ

00024501774

294

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙД

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Багa тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, И-мэйл: letter@moe.gov.mn
Вэб сайт: moe.gov.mn

2024.09.20 № 01/1131

МОНГОЛ УЛСЫН САЙД ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн 2024 оны 09 дүгээр сарын 12-ны "Боловсролын салбарын хамтын хэлэлцээртэй холбогдох асуудлаар" ХЭГ/1662 дугаартай албан бичигтэй танилцан судалж, дараах хариуг хүргүүлж байна.

(1) Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбоог Боловсролын салбарын хамтын хэлэлцээрт оролцуулахгүй байх ямар шалтгаан байгаа, хэлэлцээрт оролцох эрхтэй эсэх асуудалд:

Хөдөлмөрийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хамтын хэлэлцээр байгуулах санаачилга гаргасан этгээдийн тооноос үл хамааран тухайн түвшинд нэг хамтын хэлэлцээр байгуулна" гэж заасан.

Дээрх хуулийг үндэслэн Боловсролын яам болон Монголын Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд хамтын хэлэлцээр"-ийг байгуулахад Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтарч байгуулах эсэх асуудлаар тодруулга авахаар 2023 оны 1а/4589 дугаартай албан бичгийг Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоонд хүргүүлсэн.


Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооноос "Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбоо нь Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо болон Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоонд гишүүнчлэлгүй, төлөөлж оролцох боломжгүй талаар хариу ирүүлсэн байна.

Энэ талаар Монголын Багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбоонд тус яамнаас 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 1а/5256 дугаартай "Хариу хүргүүлэх тухай" албан бичгийг хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй тул "Боловсролын яам болон Монголын боловсрол шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд хамтын хэлэлцээр"-ийг байгуулсан болно.

Монголын Багш Нарын Үйлдвэрчний эвлэлийн холбоо Монголын Үйлдвэрчний Эвлэлийн холбоотой хамтран төлөөллөө тохиролцон оролцох тохиолдолд манай яам хамтын хэлэлцээр байгуулахад татгалзах зүйлгүй болно.

(2) Монгол Улсын Засгийн газрын зүгээс цаашдаа Хөдөлмөр нийгмийн зөвшлийн үндэсний 3 талт хэлэлцээр, салбарын болон салбарын болон салбар дундын хамтын хэлэлцээрийг үр дүнтэй боловсронгуй болгох, тэдгээрт үйлдвэрчний эвлэлүүдийн оролцоог хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг ирүүлэх асуудалд:

Боловсрол, Шинжлэх Ухааны Яам болон Монголын Боловсрол Шинжлэх Ухааны Үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд 2022-2023 онд байгуулсан хамтын хэлэлцээрийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.



П.НАРАНБАЯР

Боловсролын Сайдын
2024 оны 09 сарын 20-ны өдрийн
01/1131 дугаар тушаалын хавсралт

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ БОЛОН МОНГОЛЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ 2022-2023 ОНД БАЙГУУЛСАН ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН БИЕЛЭЛТ

Хэрэгжилт:
Хэлэлцээрт тусгагдсан ажил - 19 асуудал, хэрэгжилт – 14
Үүнээс:
- "Бүрэн хэрэгжсэн-100%" -10 ажил
- "Бүрэн хэрэгжсэн- 98%" -1 ажил
- "Хэрэгжих шатандаа – 70%"- 2 ажил
- "Хэрэгжилт хангалтгүй – 40%"-1 ажил

Асуудлууд	Биелэлт /шинэчилсэн/	Гүйцэтгэл
Нэг.Боловсруулах, шийдвэрлэх, зохион байгуулах ажлын талаар		
1.1 Боловсрол, шинжлэх ухааны салбарын хөгжлийн бодлогод нийцүүлэн баталсан аливаа зорилтот болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд боловсрол, шинжлэх ухааны салбарын ажилтны	2022 оны 11 сард, 2023 оны 02 сард болсон "Терийн болон орсн нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, багшийн туслах, албан хаагчид олгох улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам"-ын төслийн хэлэлцүүлэгт МБШУҮЭ-ийн төлөөлөл оролцсон.	100%

зохион байгуулалт, хөдөлмөрийн норм нормативтай холбоотой журам, дүрэм боловсруулах, хэлэлцүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд хамтран ажиллаж, санал, зөвлөмж өгнө.		
1.4. Боловсрол, шинжлэх ухааны сайдын болон бусад зөвлөл, ажлын хэсэгт Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөллийг оруулна	1. Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар хэлэлцсэн Боловсролын ерөнхий хууль. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Дээд боловсролын тухай хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэхэд бэлтгэх Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх Ажлын дэд хэсэгт МБШУҮЭХ-ны дарга З.Цогтгэрэл орж, хамтран ажилласан 2. БШУ-ны сайдын 2022 оны А/364 дүгээр тушаалаар батлагдсан Ажил мэргэжлийн стандарт хүний хөгжлийн хүрээлэн, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөлөлтэй хамтран ерөнхий боловсрол сургуулийн багшийн ажил үүрэгт дүн шинжилгээ хийж, ажил мэргэжлийн стандартын төсөл боловсруулах нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд МБШУҮЭ-ны Ерөнхий боловсролын сургууль хариуцсан мэргэжилтэн Б.Галбадрах орж, хамтран ажилласан. Түүнчлэн 2022-2023 онд сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын бүлгийн багш, багшийн туслах, арга зүйч, ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйч, хоол зүйчийн ажил үүрэгт дүн шинжилгээ хийж, ажил мэргэжлийн стандартын төсөл боловсруулахад хамтран ажилласан.	100%
1.5. Боловсрол, шинжлэх ухааны салбарын ажилтны хөдөлмөрлөх эрх, нийгмийн баталгаатай холбоотойгоор	Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан "Эрдэм шинжилгээний ажилтны статусын тухай зөвлөмж"-д заасан "судлаачдын эрх чөлөө, эрх үүрэг хариуцлагыг тэнцвэржүүлсэн байх" болон "шинжлэх ухаан судалгаанд зориулсан шинжлэх ухааны шударга байдал, ёс зүйн дүрэм, тэдгээрийн техникийн хэрэглээг бий болгосон байх" гэсэн заалтын хүрээнд салбарын үйлдвэрчний эвлэлтэй хамтран ажиллаж, санал аван Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" А/156 тоот тушаалаар Эрдэм шинжилгээний ажилтын ёс зүйн дүрмийг шинэчлэн батлуулсан.	

294

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас баталж гаргасан "Багшийн статус хамаарах зөвлөмж", "Их сургуулийн багшлах боловсон хүчний статусын тухай зөвлөмж" "Эрдэм шинжилгээний ажилтны статусын тухай зөвлөмж"-ийг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллана.		
1.6. Монголын багш нарын 7 дугаар их хурал болон салбарын зөвлөгөөний зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, Монголын багш нарын 8 дугаар их хурлын бэлтгэлийг ханган ажиллана.	Монголын багш нарын 7 дугаар их хурлын шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх, явц, үр дүнд хяналт тавих Зөвлөлдөх зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар Монголын багш нарын 7 дугаар их хурлын 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн тэйлан хэлэлцэх хэлэлцлээ. Хурлаар 1. "Боловсролын эрх зүйн шинэчлэл"-ийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн 2. "Боловсролын бодлого, сургалтын агуулгыг төгөлдөржүүлэх нь"-ын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн 3. "Багшийн хөгжил, ёс зүй"-ын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн 4. "Багшийн үнэлэмж, нийгмийн хамгааллыг сайжруулах нь"-ын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн гэсэн 4 чиглэлийн тайланг хэлэлцэж, хэрэгжилтийн явцыг 92.8 хувьтай байна гэж дүгнэлээ	100%

	Монголын багш нарын 8 дугаар их хурлыг хуралдуулах бэлтгэл ажлыг хангаж, Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, яамдын саналын нэгтгэн, ЗГХЭГ-т хүргүүлээд байна.	
1.7. Боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн хүрээнд боловсролын сургалтын байгууллагын төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу зарцуулахад хяналт тавьж ажиллана. Шинжлэх ухааны салбарын төсвийн шинэчлэлийн чиглэлээр судалгаа хийж, шийдвэр гаргахад санал, санаачилга гарган ажиллана	1. Боловсролын салбарын төсвийн шинэчлэлийг 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд шинэчлэлийн үйл ажиллагаа, түгээн дэлгэрүүлэх, хэрэгжилтийг хангахад Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөллийг оролцуулан байгууллага, хамт олон, багш ажиллагсдад сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамтран оролцсон Төсвийн шинэчлэлийн гол онцлог бүюу сургалтын байгууплагын хагас бие даасан тогтолцоо, үр дүнгийн санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт эргэн төвлөрүүлэхгүй байх, буцаан зарцуулдаг байх асуудлыг Боловсролын ерөнхий хууль хэлэлцүүлэх үед тусган батлуулсан. Мөн тус хуулийн заалтыг баримтлан Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг дагуулан төсвийн тухай хуульд Боловсролын салбарын гүйцэтгэл үр дүнгийн санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилд зарцуулах эрхийг авч холбогдох шийдвэрийг Улсын Их Хурлын түвшинд гаргуулсан. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэн байгууллагуудын нэмэлт орлогыг тухайн байгууллагын саналын дагуу сар бүр бүртгэж, зарцуулах ангилал тус бүрээр хуваарилан ямар нэг саадгүйгээр зарцуулах боломжийг бүдүүлсэн. 2. Шинжлэх ухааны салбарын хувьд судалгааны үйл ажиллагаа, онцлог, суурь судалгааны чиглэлээс хамааруулан суурь санхүүжилтийг жил бүр олгох журмын төслийг боловсруулан Монголын Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн Шинжлэх ухааны хорооны төлөөллийг оролцуулан санал солилцон судалгаа, шинжилгээ хийж, "Төрийн өмчит ЭШХ төвийн судалгааны үндсэн чиглэлд олгох санхүүжилтийг тооцох аргачлал" Сайдын А/120 дугаар тушаалаар аргачлал батлан хэрэгжүүлж байна	100%
Хоёр. Хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлс, нийгмийн хамгаалллын талаар		
2.1. Боловсрол, шинжлэх ухааны салбарын ажилтны	1. Боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн хүрээнд багшийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг хангах, гүйцэтгэлийн үр дүнтэй уялдуулан урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор дараах эрх зүйн актыг боловсруулан, Засгийн газрын тогтоол болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын	

858

цалин хөлсийг 2021 онд хүрсэн түвшингөөс ~~бууруулахгүй~~. чанар, гүйцэтгэлд суурилсан үр дүнд үндэслэн 30-50 хувиар нэмэгдүүлнэ	тушаалаар батлагаажуулан хэрэгжилтийг ханган ажилласан Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор сургуулийн өмнөх болон бага дунд боловсрол, мэргэжлийн боловсрол, шинжлэх ухааны ~~салбарын төрийн үйлчилгээний албан~~ хаагчийн албан тушаалын үндсэн цалингийн доод хэмжээг өмнөх сүлжээний 5 дугаар шатлалын түвшинд тогтоож, 2022 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж ажилласан Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" 107 дугаар тогтоолын 2 дахь заалтыг үндэслэн "Төрийн өмчит болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай" Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн А/122 дугаар тушаалыг батлан, батлагдсан өдрөөс эхлэн хэрэгжихээр тусгасан. Хүснэгт 27 Үндсэн цалингийн өсөх хувь (Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/122-р тушаалаар шинэчилсэн)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл				
	ТҮБД-1	ТҮБД-2	ТҮБД-3	ТҮБД-4	ТҮБД-5
5	757,907.0	911,443.0	1,005,130.0	1,063,537.0	1,126,198.0

Ингэснээр өмнөх цалингийн сүлжээнээс (Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472-р тогтоолоор) ТҮБД 3-1, 3-2 шатлалд хамрагдаж байсан ЕБС-ийн 14,957 багшийн цалин 33-34 хувиар, ТҮБД 3-3 шатлалд хамрагдаж байсан ЕБС-ийн 4,729 багшийн цалин 30 хувиар, ТҮБД 3-4 шатлалд хамрагдаж байсан ЕБС-ийн 4,733 багшийн цалин 24 хувиар, ТҮБД 3-5 шатлалд хамрагдаж байсан ЕБС-ийн 9,207 багшийн цалин 18 хувиар, ТҮБД 3-1, 3-2, 3-3 шатлалд хамрагдаж байсан СӨБ-ийн 5,361 багшийн цалин 29-30 хувиар, ТҮБД 3-4 шатлалд хамрагдаж байсан СӨБ-ийн 1,198 багшийн цалин 20 хувиар, ТҮБД 3-5 шатлалд хамрагдаж байсан 2,587 багшийн цалин 14 хувиар тус тус нэмэгдсэн. Хүснэгт 28. Үндсэн цалингийн өсөх хувь /Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/122-р тушаалаар шинэчилсэн./

200

цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл /ЕБС/			Албан тушаалын зэрэглэл /СӨБ/		
	ТҮБД-3	Багшийн тоо	Нэмэгдсэн хувь	ТҮБД-4	Багшийн тоо	Нэмэгдсэн хувь
1	749,728.0	7,720.0		818,762.0	2,134.0	
2	755,608.0	7,237.0	33%	825,523.0	2,087.0	29%
3	770,545.0	4,729.0	30%	842,702.0	1,140.0	26%
4	808,442.0	4,733.0	24%	886,281.0	1,198.0	20%
5	850,717.0	9,207.0		934,899.0	2,587.0	
Хамгийн их	850,717.0	33,626.0	34%	934,899.0	9,146.0	30%
Хамгийн бага	749,728.0	7,237.0	18%	818,762.0	1,140.0	14%
Дундаж	787,008.0	6,725.2	28%	861,633.4	1,829.2	24%

2023 оны хувьд Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсролын багшийн цалингийн хэмжээг 50 хувиас доошгүй нэмэгдүүлэх, боловсролын салбарт ажиллаж буй төрийн нийтлэг үйлчилгээний ажилчдын цалингийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэх боломжийн талаар тооцоог судалгааг гарган холбогдох газарт санал хүргүүлэн Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн нийгмийн суурь салбаруудын төрийн үйлчилгээний мэргэжлийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн нэг түвшинд тогтоож, албан тушаалын ангилал зэрэглэлийг шинэчлэн батлахад оролцоог ханган, санал тусгуулж, ажилласан.

2023 оны сүүлийн хагас жилд тус тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд БШУ-ны сайдын багцад 2023 оны төсвийн тодотголоор 416.6 тэрбум төгрөг нэмэгдүүлж, салбарын ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлсэн.

2 Багшийн гүйцэтгэл, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг Боловсролын ерөнхий хуульд тусган санхүүжүүлэх журмыг засгийн газар батлахаар заасан. Засгийн газрын 2023 оны "Боловсролын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 326 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан урамшууллын хэмжээг 50 хүртэл хувиар нэмэгдүүлэх асуудлыг судалж, шийдлийн төслийг шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн хамт боловсруулж төсвийн төсөлд тусгах саналаа хэлэлцүүлэхийг Сангийн сайд

105

Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт тус тус даалгасугай.` Гэсний дагуу Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Багшийн гүйцэтгэл, үр дүнгийн урамшууллыг үнэлгээний үр дүнгээс хамааруулан 15-40% -иар олгохоор тусган ~~яамдуудаас санал авахаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын~~ 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 1а/6142 дугаар албан бичгээр хүргүүлээд байна.

3. 2022-2023 оны хувьд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш болон ерөнхий боловсролын сургуулийн багшид олгосон гүйцэтгэл, үр дүнгийн санхүүжилт. Хүснэгт

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшид олгосон урамшуулал

Түвшин	2022 он		2023 он			
	Багшийн тоо	Менгэн дүн	Багшийн тоо	Менгэн дүн	Багшийн тоо	Менгэн дүн
I	360	646,117.4	360	538,431.2	404	607,666.50
II	711	1,020,801.8	711	850,668.3	796	957,826.80
III	709	763,456.7	709	636,213.9	810	731,004.75
IV	1126	808,438.1	1126	673,698.5	1269	763,493.85
V	3031	-	3031	-	3171	-
Нийт дүн	**5937**	**3,238,814.0**	**5,937**	**2,699,011.9**	**6450**	**3,059,991.90**

Ерөнхий боловсролын сургуулийн багшид олгосон урамшуулал

Түвшин	2022 он		2023 он			
	Багшийн тоо	Менгэн дүн	Багшийн тоо	Менгэн дүн	Багшийн тоо	Менгэн дүн
1	947	1,873,970 44	947	642,504 22	899	514,992 15
2	2982	4,720,743 56	2982	3,034,763.88	3357	2,884,586.18
3	3351	3,978,675.23	3351	4,547,057.35	3224	3,693,736 80
4	5016	3,970,363.95	5016	8,507,922.89	4827	6,912,867.38
5	17028	-	17028		15876	-
Нийт дүн	**29324**	**14,543,753.18**	**29,324.00**	**16,732,248.34**	**28183**	**14,006,182.50**

302

2.2. Боловсрол, шинжлэх ухааны салбарын ажилтны ~~хөдөлмөрийн~~ нөхцөл, ажлын онцлогийг харгалзан албан тушаалын ангилал, зэрэглэлийг өөрчлөх, нэмэгдүүлэх, олгох нэмэгдэл, нэмэгдэл хөлсний хувь, хэмжээг өсгөх асуудлаар хамтран санал боловсруулан холбогдох байгууллагаар шийдвэрлүүлнэ.	ХНХЯам-с боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, спортын салбарын үйлчилгээний албан хаагчдын цалингийн ангилал, зэрэглэлийн ялгаатай байдлыг арилган нэгтгэж ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН буюу ТҮМ ангиллыг 1-10 шатлалтай ~~байхаар 2023 оны 10 сарын 1-ээс шинэчлэх саналын хүрээнд:~~ 1. ХНХЯ-аас боловсруулсан ТҮМ ангиллын ТҮМ1, ТҮМ2, ТҮМ3 гэсэн зэрэглэлүүдийг нэгтгэх боломжтой гэж үзэж байна. Тухайлбал, Төрийн үйлчилгээ мэргэжлийн ТҮМ-1 /Ерөнхийлөгч, Шинжлэх ухааны академийн/ нь улсын хэмжээнд 1 албан тушаалтан хамрагдах, ТҮМ-2 /ШУА-ийн дэд ерөнхийлөгч/, /Эрдэмтэн нарийн бичгийн дарга/ гэсэн ангиллууд нь зөвхөн шинжлэх ухааны салбарын 2 албан тушаалтанд зориулагдсан ангиллууд байна. Эдгээрийг нэгтгэн нэг ангилал, зэрэглэлд хамруулж тесвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан үндсэн цалинг доод хэмжээг харгалзан тогтоох, гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулан /0-25 хувь/ нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгах 2 ХНХЯ-аас боловсруулсан одоогийн саналд боловсролын салбарт Сэтгэл зүйч, эмч ТҮМ-6, хоол зүйч, эмч ТҮМ-7 ангилалд тогтоохоор төсөл боловсруулсныг Сэтгэл зүйч, Хоол зүйч, мөн эмч гэсэн албан тушаалыг ТҮМ-5 ангилалд хамааруулахаар өөрчлөх, мөн ТҮМ-8 ангилалд номын санч гэснийг ТҮМ-6 ангилалд шилжүүлж тус тус өөрчлөх; 3 ТҮМ-5 ангилалд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хариуцсан ажилтан, ТҮМ-9 ангилалд Хичээл зохицуулагч гэж тус тус нэмэх; 4 ХНХЯ-аас боловсруулсан ТҮМ ангилал, зэрэглэлд одоогийн боловсролын салбарын ТҮБД1-5 ангилал, зэрэглэлийг хөрвүүлэхдээ мэргэжлийн боловсрол ТҮМБ1-7, соёлын салбарын ТҮСУ1-7 ангилал зэрэглэлтэй дүйцүүлэх, шаардлагатай зарим удирдах, гүйцэтгэх албан тушаалтны ангиллыг бусад салбарын ижил мэргэжилтэй дүйцүүлж, одоогийн түвшнийг бууруулахгүй байхаар шинэчлэн тогтоох саналыг үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөлөлтэй хамтран боловсруулж, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	100%
2.3. Ажлын чиг үүрэг, ачааллын судалгаанд үндэслэн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш,	2022-2023 онд Ажил мэргэжлийн стандарт хүний хөгжлийн хүрээлэн, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөлөлтэй хамтран ерөнхий боловсрол сургуулийн багш, сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын бүлгийн багш, багшийн туслах, арга зүйч, ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйч, хоол зүйчийн ажил үүрэгт дүн шинжилгээ хийж, ажил мэргэжлийн стандартын төсөл боловсруулахад хамтран ажилласан	70%

505

туслах багшид нэмэгдэл болон нэмэгдэл хөлс олгох чиглэлээр хамтарч ажиллана		
2.4. Шинжлэх ухааны салбарын онцлог, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээг харгалзан салбарын ажилтны дотоод албан томилолтын зардалд өөрчлөлт оруулах чиглэлээр хамтран ажиллана	"Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тоот тушаал батлагдлаа. Өмнө нь буюу 2018 оны арван хоёрдугаар сарын 27-нд батлсан тушаалаар төрийн албан хаагчийн албан томилолтын зам хоногийн зардлыг суманд 12,000 төгрөг, аймгийн төвд 14,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 16,000 төгрөгөөр, байрны зардлын хэмжээг суманд 14,500 төгрөг, аймгийн төвд 36,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 53,000 төгрөгөөр тус тус тогтоож байжээ Шинэчлэн батлагдсан тушаалаар төрийн албан хаагчийн дотоод албан томилолтын хоолны зардлыг суманд 24,000 төгрөг, аймгийн төвд 28,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудад 32,000 төгрөгөөр, байрны зардлыг суманд 40,000 төгрөг, аймгийн төвд 90,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудад 110,000 төгрөгт хүргэж нэмэгдүүлэн баталлаа.	40%
2.5. Боловсрол, шинжлэх ухааны салбарын ажилтныг орон сууцаар хангах чиглэлээр санал санаачилга гаргаж хамтран ажиллана.	Боловсролын багц хуулийг батлуулахтай холбоотой ажлын хэсэгт Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэл, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан тэдгээрийн санал, зөвлөмжийг тусган ажиллаж "Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх" асуудлыг Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. дэх хэсэгт тусган батлуулж орон сууцаар хангах эрх зүйн орчныг бүрдүүлэзд байна.	70%
2.6. Багш, эрдэм шинжилгээний ажилтны мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэхэд	Багшийн мэргэжил эзэмших, багшийн тасралтгүй хөгжлийн төлөөр Боловсролын ерөнхий хуульд тусган хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2023 оны "Боловсролын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 326 дугаар тогтоолын санаачлан батлуулсан Тус тогтоолд Багш бэлтгэх, багшийн тасралтгүй хөгжих боломж, нийгмийн баталгааг хангах хүрээнд дараах арга хэмжээ авч	100%

305

дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллана	хэрэгжүүлэх. Магадлан итгэмжлэгдсэн багш мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж байгаа суралцагчдын сургалтын төлбөр, багш нарыг магистрын болон гадаад, дотоодод мэргэшүүлэх сургалтад суралцуулахад дэмжлэг үзүүлэх тухай тусган дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлээд байна. Шинжлэх ухааны ажилтны хувьд гадаад суралцах, мэргэжлээ дээшлүүлэхэд тухай байгууллагын удирдлага, ажилтны хооронд гэрээ байгуулан ажлын байрыг хадгалах, суралцаж буй хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг байгууллагаас төлөх асуудлыг тус гэрээнд тусган хэрэгжүүлж байна. Мөн боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн хүрээнд хувьсах зардлыг бүрэлдэхүүнд багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих зардлыг тусган багшийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан Модуль сургалтуудыг Боловсролын ерөнхий газраас 2022-2023 онуудад төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран зохион байгуулж, багшийн ажлын байрандаа тасралтгүй хөгжих нөхцөлийг бүрдүүлж, бүрэн хэрэгжүүлж байна. үүнд. Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны багшийн хөгжлийг дэмжих зардалд 6.7 тэрбум, цэцэрлэгийн багшийн хөгжлийг дэмжих зардалд 1 3 тэрбум төгрөг зарцуулсан. 2023 оны ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжлийг дэмжих зардалд 7 1 тэрбум, цэцэрлэгийн багшийн хөгжлийг дэмжих зардалд 1 8 тэрбум төгрөг зарцуулагдахаар батлагдсан бөгөөд давхардсан тоогоор 66502 багш багшийн хөгжлийг дэмжих модуль сургалтад хамрагдаад байна	
2.7. Гадаадад урт, богино хугацаанд мэргэжил дээшлүүлэх сургалт, магистрантур. докторантурт суралцахад байгууллага нь тухайн ажилтантай гэрээ байгуулж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон	Шинжлэх ухааны ажилтны хувьд гадаад суралцах, мэргэжлээ дээшлүүлэхэд тухай байгууллагын удирдлага, ажилтны хооронд гэрээ байгуулан ажлын байрыг хадгалах, суралцаж буй хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг байгууллагаас төлөх асуудлыг тус гэрээнд тусган хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон нийгмийн даатгалын шимтгэлийг төлж байна	

Commented [БӨТ1]: ШУА аас гадаада, хүн суралцаж байгаа, хэдэн төгрөгийн Н, талаар мэдээлэл авч 1-2 өгүүлбэр оруул Эрдэнэ-Очир

505

нийгмийн даатгалын шимтгэлийг төлж байх талаар хамтарсан санал боловсруулж, холбогдох газарт хүргүүлнэ.		
2.8. Төрийн өмчийн их сургуулийн багш, ажилтан нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг бусад төрийн албаны хаагч, боловсролын салбарын ажилтантай ижил зарчмаар олгож, санхүүжүүлнэ.	Боловсролын багц хуулийг батлуулахтай холбоотой ажлын хэсэгт Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэл, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан тэргэрийн санал, зөвлөмжийг тусган ажиллаж Улсын Их Хурлаар багц хууль батлагдахад "дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу тэтгэмжийг тухайн боловсролын сургалтын байгууллагаас олгох," асуудлыг Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.5. дэх хэсэгт тусган хууль зрх зүйн орчныг бүрдүүлээд байна.	100%
Гурав. Төсөв санхүүгийн талаар		
3.1. Боловсрол, шинжлэх ухааны байгууллагуудын төвшинд төсвийн төсөл боловсруулахдаа Монголын Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний	Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн зохицуулагчийн 2024 оны төсвийн төсөлд харьяа байгууллага, төсвийн шууд захирагч нараас ирүүлсэн саналууд болон салбарын хэмжээнд дунд болон урт хугацаанд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүлээгдэж буй шийдвэрлэх асуудлуудыг тооцож үзэхэд нийт 6,498.8 тэрбум төгрөгийн зардал төсөвлөгдөж, үүнээс урсгал зардалд 4,454.3 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 2,044.6 тэрбум төгрөг байхаар тус тус тооцож төсөлд тусган 8 дугаар сарын 14-ны өдөр үйлдвэрчний эвлэлд танилцуулсан	100%

306

эвлэлийн холбооны оролцоог хангаж ажиллана.		
3.2 Улсын төсвийн орлогын 20-оос доошгүй хувийг боловсролын салбарт зарцуулдаг зааltыг Боловсролын тухай хуульд сэргээж тусгана Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.1 дүгээр зааltын хүрээнд Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, судлаачийн чадавхыг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг 4 дахин нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллана.	Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсөв 2023 онд 2,687.4 тэрбум төгрөгөөр батлагдсан боловч УИХ-аас 2023 оны 6 дугаар сард хийсэн төсвийн тодотголоор Терийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 7 сарын 1-ээс эхлэн нэмэгдүүлж шийдвэрлэх болсонтой холбогдуулан цалингийн санд 416.6 тэрбум төгрөг нэмэгдэж нийт төсөв 3,104.0 тэрбум төгрөгөөр батлагдсан Харин ЗГ-ын 2023 оны 245 дугаар тогтоолоор 2024 оны төсвийг батлахад хөрөнгийн зардлын хэмжээг -126.7 тэрбум төгрөг буюу 23.9 хувиар бууруулсан байна. Манай улсын хувьд ковид-19 цар тахлын үед Боловсрол, шинжлэх ухааны салбарт хуваарилж, зарцуулж буй төсөв 2021 оны гүйцэтгэлээр ДНБ-ий 3.9 хувь, төсвийн нийт зарлагын 10.8 хувь хүртэл буурсан бол 2022-2023 онд ДНБ-ий 4.4-4.9%, улсын төсвийн нийт зарлагын 12.8-13.2% хүртэлх хэмжээнд нэмэгдэхээр төлөвлөгдөж, улмаар энэ үзүүлэлт 2023 оны төсийн тодотголоор ДНБ-ий эзлэх хувь 5.2%, нэгдсэн төсвийн нийт зарлагын 13.8%-д хүрсэн Харин ЗГ-аас баталсан 2024 оны төсвийн хязгаарт БШУ-ны төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн нийт зарлага нь ДНБ-ий 4.5%, төсвийн нийт зарлагын 12%-тай дүйцэхүйц хэмжээнд төсөөлөгдөв.	100%

302

3.3. Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативыг жил бүр шинэчлэн тогтоохдоо хичээл практикийн зардлыг нэмэгдүүлнэ	Боловсролын салбарын 2022 оноос хойш хэрэгжиж буй төсвийн шинэчлэлийн хүрээнд мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт санхүүжилтийн тогтолцоогоор нь дамжуулж төсвийн нэг төгрөг бүрийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хагас бие даасан, мэргэжлийн өөрийн ертгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардал, үр дүн, чанар, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт, төсвийн шинэчлэлийг Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын 2023 оны батлагдсан төсөвт багтаан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, багш ажилчдын нийгмийн баталгааг хангах боломжийг бүрдүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх өөрчлөлтүүдийг тусгасан эрх зүйн орчныг бий болгоод байна. Салбарын төсвийн шинэчлэлийн үр дүнд хүүхэд, суралцагч хаана сурч байгаагаас үл хамааран төсвөөс хуваарилах санхүүжилт ижил зарчмаар олгогдог байх, харин үйлчилгээ үзүүлэгч сургалтын байгууллагын гүйцэтгэл үр дүнг үнэлж, цаашдын бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд харгалзан үзэх замаар чанарын ялгаатай байдлыг арилгах, сайжруулах боломж ийг бүрдүүлсэн. 1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив батлаж хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор багш, эцэг эхээс гардаг байсан хичээл практикийн зардлыг тус хувьсах зардалд тусган санхүүжүүлж эхэлсэн. 2022 онд нийт .... төгрөг, 2023 онд нийт .... төгрөгийг төр, хувийн хэвшлийн хувьсах зардлаар санхүүждэг байгууллагуудад олгоод байна.	
3.4. Боловсрол, шинжлэх ухааны байгууллагын төсвийн ил тод байдлыг хангахын тулд Шилэн дансны тухай хууль, Авлигын эсрэг хууль болон нийцүүлэн баталсан бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлнэ.	Боловсрол, шинжлэх ухааны салбарын байгууллагуудын хувьд нийтийн ил тод мэдээллийн тухай хууль, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж байна. 2022-2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд үндэсний аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлангаар төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим системийн хөтлөлт, мэдээллийн чанарт дүгнэлт зөвлөмж гарган /аудитын код СНАГ-2023/05/НА-СТА-ТЕ3/ ирүүлсэн. Тус аудитын тайланд 1761 байгууллага 263,291 мэдээлэл байршуулахаас бүх мэдээллийг байршуулсан бөгөөд хугацаа хоцорч байршуулсан 15,570 мэдээлэлтэй бөгөөд үнэлгээгээр 98 хувьтай үнэлэгдсэн байна.	98%
3.5 Төрийн албаны шинэчлэлтэй холбоотойгоор төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн хамгаалал, эрх ашгийг хохироосон эрх зүйн зохицуулалт оруулахгүй байх, орсныг өөрчлөх, сайжруулахад хамтран ажиллана.		

302

3.6 Төрийн өмчийн их, дээд сургуулиудын эрдэм шинжилгээ, судалгааны зардал, тогтмол зардал болон бусад зардлыг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлберийн 2 3.14 дүгээр заалтын дагуу төрөөс дэмжлэг үзүүлнэ	Дээд боловсролын тухай хуулийн /шинэчилсэн найруулгаар/ 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь хэсэгт заасны дагуу төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан тул 2024 онд нийт 14.2 тэрбум төгрөг төсвийн төсөлд тусган боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн.	
3.7 Төсвийн шууд захирагч нар батлагдсан төсвөө захиран зарцуулахад хуулиар олгогдсон эрхэд нь халдахгүй байхад хяналт тавьж ажиллана.	Боловсрол, шинжлэх ухааны төсвийн шинэчлэлийн хүрээнд төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь заалтын дагуу өөрт олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллах үүгийг хүлээсэн. Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон бусад хамаарал бүхий байгууллагаас хуулиар хүлээсэн эрх, үүрэгт халдсан ямар нэг зөрчил, дутагдал үүсээгүй, гараагүй болно.	100%
Дөрөв. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хяналт тавих, дүгнэж нэмэлт өөрчлөлт оруулах талаар		
4.1 Энэхүү хэлэлцээрт заагдсан нөхцөл баталгаанаас дордуулсан хууль, тогтоомж гарсан тохиолдолд тус хэлэлцээрийг мөрдөнө.		
4.2 Боловсрол, шинжлэх ухааны яам, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоотой байгуулах хамтын гэрээ, хэлэлцээрийг дараа оны төсвийн төслийг боловсруулахаас өмнө буюу 1 дүгээр улиралд байгуулна.		
4.3 Боловсрол, шинжлэх ухааны яам, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, бүх шатны боловсролын сургалтын болон шинжлэх ухааны байгууллага нь энэ хэлэлцээрээр тохиролдсон нөхцөлтэй холбоотой тушаал, журам гаргахдаа хэлэлцээрийн зүйл, заалтуудыг харгалзаж үзнэ.		

309

4.4. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх талаар Боловсролын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, бүх шатны боловсролын сургалтын болон шинжлэх ухааны байгууллагын удирдлагад чиглэлийг хүргүүлнэ.	
4.5. ~~Хэлэлцээрт талууд гарын үсэг зурж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд бүрттүүлснээр хүчин төгөлдөр~~ болж, 2 жилийн хугацаанд мөрдөх бөгөөд дараагийн хамтын хэлэлцээр байгуулагдах хүртэл хүчинтэй байна	
4.6. Талууд хэлэлцээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр баталж байгуулж хэрэгжүүлнэ	
4.7. Хамтарч гүйцэтгэх ажлыг талуудаас томилогдсон ажлын хэсэг зохион байгуулж хэрэгжүүлнэ.	
4.8. Хэлэлцээрийн биелэлтийг хагас жил тутам хэлэлцэж, төлөвлөгөөний хэрэгжилтийг жил тутам гаргаж, 2 талын хамтарсан хурлаар хэлэлцэн дүгнэж байна.	
4.9. Талуудын аль нэгний санаачилгаар хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээр байгуулсан зарчмын дагуу тухай бүр хамтран шийдвэрлэнэ	

---oOo---

311

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын 7 байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/факс: (976-51) 26 79 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.09.19 № 1/4939
танай 2024.09.12-ны № ЗТГ/1662 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Н.УЧРАЛ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Боловсролын салбарын хамтын хэлэлцээрийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн ирүүлсэн асуулттай танилцаад дараах хариуг хүргүүлж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг энэ хуулийн 18, 19, 20, 21, 22, 23, 24 дүгээр зүйлд заасан журмын дагуу байгуулна." гэж заасны дагуу хамтын хэлэлцээр байгуулна.

Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "хамтын хэлэлцээр" гэж хүний хөдөлмөрлөх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улс, аймаг, сум, нийслэл, дүүрэг, салбар, салбар дундын хэмжээнд холбогдох талуудын хооронд байгуулж, зохих журмын дагуу бүртгүүлсэн тохиролцоог" гэж, мөн хуулийн 12 дугаар зүйлд 12.1-д "Ажил олгогч, ажил олгогчийн төлөөлөгч хамтын гэрээ, хамтын хэлэлцээр байгуулах зорилгоор ажилтны төлөөлөгчтэй хамтын хэлэлцээ хийх, ажилтантай харилцан тохирч хөдөлмөрийн гэрээ, түүнийг дагалдах гэрээг байгуулах бөгөөд хөдөлмөр, нийгмийн хамгааллын харилцааны асуудлаар хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг тогтоох эрхтэй." гэж тус тус хамтын хэлэлцээрт тавигдах шаардлагыг заасан.

Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг талууд хамтын хэлэлцээ хийх замаар байгуулна." гэж, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Тухайн байгууллагад хоёр, түүнээс дээш үйлдвэрчний эвлэл байвал тэдгээр нь тохиролцож, хамтарсан төлөөлөгчид томилон захиргаа, эздэтэй хамтын нэг гэрээ байгуулна." гэж заасан тул Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбоо нь Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоотой зөвшилцөн, хамтын хэлэлцээнд оролцох хамтарсан төслийг зохих хууль тогтоомжийн дагуу Боловсролын яаманд гаргах нь зүйтэй байна.

Түүнчлэн, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн үндэсний гурван талт хэлэлцээр, салбарын болон салбар дундын хамтын хэлэлцээрүүдийг үр дүнтэй, боловсронгуй болгох, тэдгээрт үйлдвэрчний эвлэлүүдийн оролцоог хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээлэл ирүүлэхийг хүсэсэн нь тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй тул хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас дээрх мэдээллийг авах нь зүйтэй.

О.АЛТАНГЭРЭЛ

А4 Файл.2024
151602139

МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Нэгдсэн үндэстний гудамж 5,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 15 53, Факс: 32 86 34,
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2024.09.19 № 01/8092

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Тайлбар хүргүүлэх тухай

Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбооноос Боловсролын салбарын хамтын хэлэлцээний талаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяад тавьсан хүсэлт, түүнтэй холбоотой ирүүлсэн асуулттай танилцлаа.

1.Хөдөлмөрийн тухай хуулийн 13.1-д "нийгмийн түншлэл нь хөдөлмөр харилцаа, түүнтэй холбоотой асуудлаар холбогдох талуудын ашиг сонирхлыг уялдуулах замаар нийгмийн зөвшилцөл бүрдүүлэхэд чиглэсэн ажил олгогч болон ажилтан, тэдгээрийн төлөөлөгчид, төрийн байгууллага хоорондын хоёр болон гурван талт хамтын ажиллагаа мөн." гэж заасан.

Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбоо нь Хөдөлмөрийн тухай хуулийн 20.3, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хуулийн 4 дүгээр зүйлийн 3, 5 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 87 дугаар конвенцын 5, 7 дугаар зүйл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 8 дугаар зүйлийн (b) хэсэгт заасны дагуу Боловсролын салбарын хамтын хэлэлцээнд төлөөллөө оролцуулах эрхтэй болно.

Хөдөлмөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "... салбарын хэмжээнд хэд хэдэн үйлдвэрчний эвлэл, ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага байвал хамтын хэлэлцээнд оролцох төлөөлөгчдийн тоог гишүүдийнхээ тооны харьцааг үндэслэн тогтооно." гэж. 21.1-д "хамтын хэлэлцээг санаачлагч тал нь хамтын хэлэлцээ хийх тухай мэдэгдлийг хэлэлцээ хийх бүрэлдэхүүн, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр шийдвэрлэх асуудлын талаарх саналын хамт нөгөө талдаа бичгээр хүргүүлнэ." гэж тус тус заасан.

Иймд дээр дурдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх асуудлаар Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбоо нь Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоотой зөвшилцөн боловсролын салбарын хамтын хэлэлцээрт үйлдвэрчний эвлэлийг төлөөлөх төлөөлөгчдийн тооны харьцааг тогтоох нь зүйтэй. Уг холбооны төлөөллийг салбарын хэлэлцээнд оролцуулаагүй маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлээгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлэх боломжтой.

2.Монгол Улсын Засгийн газраас Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт улсын хэлэлцээр, аймаг, нийслэл, салбар, салбар дундын хамтын хэлэлцээрийн үр дүнг сайжруулах, үйлдвэрчний эвлэлүүдийн оролцоог хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно:


153240753

D: 2024 on 09 sar A4

a.2000 оноос эхлэн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт улсын хэлэлцээрийг 2 жилд 1 удаа буюу нийт 8 удаа байгуулж, хэрэгжүүлэх ажлыг Засгийн газар, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран зохион байгуулсан. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны хэлэлцээрт Нийгмийн түншлэлийг бүх түвшинд хөгжүүлэх, нийгмийн тэгш байдлыг хангах, хамтын хэлэлцээ хийх чадавхыг сайжруулах, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх тогтолцоог сайжруулахад нийгмийн түншүүд хамтран ажиллах зорилтыг тусгасан бөгөөд энэ зорилтын хүрээнд салбар, салбар дундын түвшинд хамтын хэлэлцээ хийх, байгуулах, хэрэгжилтийг хангахад арга зүйн зөвлөмж, чиглэл өгч хамтран ажиллах, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр салбар хороод болон аймаг, нийслэлийн хороодыг байгуулахаар төлөвлөөд байна.

b.Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хууль нь 1991 онд батлагдсан бөгөөд тус хуулийн зарим зохицуулалтууд эрх зүйн шинэчлэлээс хоцорсон төдийгүй давхардал, хийдэл, зөрчлийг үүсгэж байгаа тул хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж, батлуулах шаардлагатай байна. Хуулийн шинэчилсэн найруулгаар үйлдвэрчний эвлэлийн гишүүн, байгууллагын, салбарын, орон нутгийн, мэргэжил үйлдвэрлэлийн Үйлдвэрчний эвлэл, хороо, холбоо, идэвхтэн сонгуульгы эрх, үүргийг тодорхойлж, эвлэлдэн нэгдэх эрхийг хангах, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын гишүүдийнхээ өмнө хүлээх үүрэг, эрхийг тодорхойлох, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлох, гишүүнчлэлийн татвар, бүрдүүлэлт, зарцуулалтын ил тод байдлыг зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Хүндэтгэсэн,



Л.ЭНХ-АМГАЛАН

D: 2024 on 09 sar A4